

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	17
3.1. Ерөнхий зүйл.....	17
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	17
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	18
3.4. Материаллаг байдал.....	18
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	19
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	20
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	21
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
3.9. Аудитын илрүүлэлт.....	21
Залруулсан алдаа	21
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	22
Аудитын зөвлөмж	23
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	23
4. Менежментийн захидал.....	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	26



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

АХМАД НАСТНЫ ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ДАРГА Л.ЭРДЭНЭХҮҮ
ТАНАА

2021.02.05 № 07/558
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ахмад настны үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ахмад настны үндэсний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг, хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

СТ-1А

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>418,011,717.89</u>	<u>446,751,708.62</u>
33	АВЛАГА	1,241,400.00	1,350,627.18
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,241,400.00	30,627.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,320,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	62,731,712.96
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	62,731,712.96
35	БАРАА МАТЕРИАЛ	416,770,317.89	382,669,368.48
351	Түүхий эд материал	286,585,800.42	217,526,483.07
35110	Тусгай зориулалттай материал	261,807,230.78	165,391,364.05
35130	Эм боох материал	24,778,569.64	33,780,566.26
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	-	18,234,552.76
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	120,000.00
354	Хангамжийн материал	130,184,517.47	165,142,885.41
35410	Бичиг хэргийн материал	9,072,685.50	9,072,028.00
35420	Аж ахуйн материал	-	13,800,200.00
35470	Бусад хангамжийн материал	120,041,831.97	139,480,845.21
35600	Түлш шатах тослох материал	1,070,000.00	2,789,812.20
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,039,457,927.19</u>	<u>3,048,845,687.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,039,457,927.19	3,048,845,687.45
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	2,982,792,927.19	2,394,871,596.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,009,464,064.01	2,009,464,064.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,488,689.64)	(92,436,056.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,045,902.23	192,045,902.23
39204	Хуримтлагдсан элэгдэл	(166,937,549.24)	(179,329,852.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,921,194,843.65	3,964,953,683.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,012,289,145.29)	(3,568,437,901.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	213,377,407.85	213,377,407.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(127,643,906.38)	(144,835,651.54)
39214	Номын фонд	70,000.00	70,000.00
393	Биет бус хөрөнгө	56,665,000.00	653,974,091.20
39301	Програм хангамж	935,000.00	598,244,091.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	(935,000.00)	(935,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	56,665,000.00	56,665,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,457,469,645.08</u>	<u>3,495,597,396.07</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>30,759,586.19</u>	<u>60,467,057.96</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,759,586.19	60,467,057.96
413	Өглөг	-	254,971.77
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	254,971.77

414	Урьдчилж орсон орлого	30,759,586.19	60,212,086.19
41440	Бусад урьдчилж орсон орлого	30,759,586.19	60,212,086.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,426,710,058.89</u>	<u>3,435,130,338.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>3,426,710,058.89</u>	<u>3,435,130,338.11</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,910,706,267.63	1,910,706,267.63
51101	Өмч: - төрийн	1,910,706,267.63	1,910,706,267.63
512	Хуримтлагдсан үр дүн	<u>293,591,587.66</u>	<u>302,011,866.88</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	899,589,357.07	293,591,587.66
51220	Тайлант үеийн үр дүн	(605,997,769.41)	8,420,279.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,222,412,203.60	1,222,412,203.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,457,469,645.08</u>	<u>3,495,597,396.07</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,003,025,973.71	2,646,661,179.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,284,059.71	770,439,693.40
120	Нийтлэг татварын бус орлого	195,284,059.71	770,439,693.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	195,284,059.71	770,439,693.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	168,249,975.00	128,053,768.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	27,034,084.71	642,385,925.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,807,741,914.00	1,876,221,486.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,222,477,200.00	1,195,305,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,222,477,200.00	1,195,305,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,352,000.00	10,643,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,002,000.00	6,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	4,143,410.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас	580,912,714.00	670,272,876.00
132001	Эрүүл мэндийн даатгалын сангаас	580,912,714.00	670,272,876.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,609,023,743.12	2,638,240,900.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,609,023,743.12	2,638,240,900.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,543,279,028.90	2,481,650,353.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	982,983,817.23	1,080,958,561.33
210101	Үндсэн цалин	775,794,269.22	875,378,925.10
210102	Нэмэгдэл	155,957,266.82	156,436,964.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	51,232,281.19	49,142,671.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,031,685.54	135,515,147.52
210201	Тэтгэврийн даатгал	82,033,885.76	94,997,268.03
210202	Тэтгэмжийн даатгал	10,084,230.06	11,176,149.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,862,584.05	8,631,799.52
210204	Ажилгүйдлийн даатгал	1,731,907.79	1,882,720.21
210205	Эрүүл мэндийн даатгал	17,319,077.88	18,827,210.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,948,397.71	43,393,105.21
210301	Гэрэл, цахилгаан	18,360,143.00	18,521,794.70
210302	Түлш, халаалт	13,288,767.71	14,310,905.91
210303	Цэвэр, бохир ус	10,299,487.00	10,560,404.60
2104	Хангамж, бараа материалын зардал	56,075,670.01	57,636,315.22
210401	Бичиг хэрэг	9,320,487.50	13,927,847.50
210402	Тээвэр, шатахуун	4,952,040.00	3,667,212.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,290,522.15	4,255,485.97

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,551,500.00	16,458,952.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,239,610.00	19,326,817.75
210408	Бараа материал акталсны зардал	14,721,510.36	00.00
2105	Нормативт зардал	527,631,265.85	441,110,269.57
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	321,539,770.60	290,749,192.39
210502	Хоол	175,000,000.00	139,413,537.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,091,495.25	10,947,540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,583,800.00	15,330,113.00
210604	Урсгал засвар	13,960,000.00	14,275,413.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,623,800.00	1,054,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,555,597.00	40,858,671.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,520,000.00	15,217,327.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	4,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	289,332.00	396,252.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,450.00	232,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,500.00	1,870,000.00
210807	Газрын төлбөр	348,250.00	749,792.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	34,122,065.00	14,315,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	746,468,795.56	666,848,170.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,096,000.00	768,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,446,865.00	34,400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	707,925,930.56	631,680,170.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,744,714.22	156,590,546.39
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	34,012,500.00	26,236,419.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,012,500.00	26,236,419.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	23,659,850.00
	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,412,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	2,576,569.00
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,282,214.22	130,354,127.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,282,214.22	128,930,717.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	450,000.00	1,423,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	450,000.00	1,423,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(605,997,769.41)	8,420,279.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(605,997,769.41)	8,420,279.22

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,953,052,329.00	1,033,607,754.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	145,310,415.00	57,386,268.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,310,415.00	57,386,268.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,310,415.00	157,386,268.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	145,310,415.00	157,386,268.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	145,310,415.00	157,386,268.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,807,741,914.00	1,876,221,486.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,222,477,200.00	1,195,305,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,222,477,200.00	1,195,305,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,352,000.00	10,643,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,002,000.00	6,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	4,143,410.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	580,912,714.00	670,272,876.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	580,912,714.00	670,272,876.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,953,544,348.00	2,033,607,754.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,953,544,348.00	2,033,607,754.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,887,799,633.78	1,875,697,207.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	983,538,562.23	1,058,024,164.25
210101	Үндсэн цалин	542,146,409.00	561,028,050.67
210102	Нэмэгдэл	333,333,653.23	413,929,866.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	108,058,500.00	83,066,247.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,039,036.97	156,983,800.00
210201	Тэтгэврийн даатгал	111,135,036.97	110,470,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,976,100.00	11,628,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,980,800.00	9,302,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,995,100.00	2,325,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,952,000.00	23,256,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,948,397.71	43,393,105.21
210301	Гэрэл, цахилгаан	18,360,143.00	18,521,794.70
210302	Түлш, халаалт	13,288,767.71	14,310,905.91
210303	Цэвэр, бохир ус	10,299,487.00	10,560,404.60
2104	Хангамж, бараа материалын зардал	41,117,613.15	57,763,771.97
210401	Бичиг хэрэг	7,905,471.00	5,334,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,022,040.00	4,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,290,522.15	4,255,485.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,551,500.00	15,465,800.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,348,080.00	28,108,286.00
2105	Нормативт зардал	568,723,929.72	456,296,382.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	346,737,181.00	293,598,245.00
210502	Хоол, хүнс	192,451,748.72	139,413,537.18
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	29,535,000.00	23,284,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,702,800.00	18,569,613.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	2,742,800.00	4,864,200.00
210604	Урсгал засвар	13,960,000.00	13,705,413.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,716,099.00	49,398,371.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,520,000.00	15,605,027.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	8,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	289,332.00	396,252.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,450.00	232,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	962,500.00	1,870,000.00
210807	Газрын төлбөр	348,250.00	749,792.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	27,282,567.00	22,467,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,013,195.00	35,268,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,096,000.00	768,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,917,195.00	34,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,744,714.22	157,910,546.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,012,500.00	26,236,419.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,659,850.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,412,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	2,576,569.00
2134	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,282,214.22	128,930,717.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,282,214.22	128,930,717.39
213404	Хөрөнгийн	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	450,000.00	2,743,410.00
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213502	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт санхүүжилт/	450,000.00	2,743,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(492,019.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(492,019.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	492,019.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагд-сан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,706,267.63	1,222,412,203.60	899,589,357.07	4,032,707,828.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,910,706,267.63	1,222,412,203.60	899,589,357.07	4,032,707,828.30
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			(605,997,769.41)	(605,997,769.41)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,706,267.63	1,222,412,203.60	293,591,587.66	3,426,710,058.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,910,706,267.63	1,222,412,203.60	293,591,587.66	3,426,710,058.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			8,420,279.22	8,420,279.22
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,706,267.63	1,222,412,203.60	302,011,866.88	3,435,130,338.11

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн анги-лал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,123,677,600.00	1,894,033,626.61	229,643,973.39	89.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,123,677,600.00	1,894,033,626.61	229,643,973.39	89.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,094,858,100.00	1,867,797,207.61	227,060,892.39	89.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,197,843,700.00	1,058,024,164.25	139,819,535.75	88.33
210101	Үндсэн цалин	624,148,800.00	561,028,050.67	63,120,749.33	89.89
210102	Нэмэгдэл	465,636,400.00	413,929,866.13	51,706,533.87	88.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	108,058,500.00	83,066,247.45	24,992,252.55	76.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,983,800.00	156,983,800.00	-	100
210201	Тэтгэврийн даатгал	110,470,200.00	110,470,200.00	-	100
210202	Тэтгэмжийн даатгал	11,628,400.00	11,628,400.00	-	100
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,302,600.00	9,302,600.00	-	100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,325,700.00	2,325,700.00	-	100
210205	Эрүүл мэндийн даатгал	23,256,900.00	23,256,900.00	-	100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,342,500.00	43,393,105.21	11,949,394.79	78.41
210301	Гэрэл, цахилгаан	21,859,200.00	18,521,794.70	3,337,405.30	84.73
210302	Түлш, халаалт	17,014,600.00	14,310,905.91	2,703,694.09	84.11
210303	Цэвэр, бохир ус	16,468,700.00	10,560,404.60	5,908,295.40	64.12
2104	Хангамж, бараа материалын зардал	62,309,100.00	56,363,771.97	5,945,328.03	90.46
210401	Бичиг хэрэг	5,491,500.00	4,514,200.00	977,300.00	82.2
210402	Тээвэр, шатахуун	7,411,500.00	4,600,000.00	2,811,500.00	62.07
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,725,600.00	4,255,485.97	470,114.03	90.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,471,800.00	15,465,800.00	6,000.00	99.96

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,208,700.00	27,528,286.00	1,680,414.00	94.25
2105	Нормативт зардал	509,732,300.00	456,296,382.18	53,435,917.82	89.52
210503	Эм элдмэл,эмнэлэгийн хэрэгсэл	327,118,400.00	293,598,245.00	33,520,155.00	89.75
	Хоол хүнс	153,677,900.00	139,413,537.18	14,264,362.82	90.72
	Нормын хувцас зөөлөн эдлэл	28,936,000.00	23,284,600.00	5,651,400.00	80.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,570,000.00	18,569,613.00	387.00	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,864,200.00	4,864,200.00	-	100
210604	Урсгал засвар	13,705,800.00	13,705,413.00	387.00	100
2107	Томилолт, зочны зардал	1,152,900.00	-	1,152,900.00	0
210702	Дотоод албан томилолт	1,152,900.00	-	1,152,900.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,601,000.00	49,398,371.00	9,202,629.00	84.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,116,800.00	15,605,027.00	5,511,773.00	73.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,000,000.00	8,000,000.00	-	100
210803	Даатгалын үйлчилгээ	1,411,100.00	396,252.00	1,014,848.00	28.08
210804	Тээврийн хэрэгслийн татвар	346,500.00	232,800.00	113,700.00	67.19
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	77,000.00	55,000.00	58.33
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,870,000.00	1,870,000.00	-	100
210807	Газрын төлбөр	792,000.00	749,792.00	42,208.00	94.67
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	24,932,600.00	22,467,500.00	2,465,100.00	90.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,322,800.00	28,768,000.00	5,554,800.00	83.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,712,700.00	768,000.00	944,700.00	44.84

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,610,100.00	28,000,000.00	4,610,100.00	85.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,819,500.00	26,236,419.00	2,583,081.00	91.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,819,500.00	26,236,419.00	2,583,081.00	91.04
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,659,900.00	23,659,850.00	50.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,159,600.00	2,576,569.00	2,583,031.00	49.94
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,123,677,600.00	1,894,033,626.61	229,643,973.39	89.19
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,195,305,200.00	1,066,374,482.61	128,930,717.39	89.21
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,195,305,200.00	1,066,374,482.61	128,930,717.39	89.21
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	798,372,400.00	670,272,876.00	128,099,524.00	83.95
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	798,372,400.00	670,272,876.00	128,099,524.00	83.95
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,000,000.00	157,386,268.00	(27,386,268.00)	121.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	157,386,268.00	(27,386,268.00)	121.07
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	#DIV/0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	#DIV/0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64	64	-	100
620001	Удирдах ажилтан	3	3	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	40	40	-	100
620003	Үйлчлэх ажилтан	21	21	-	100

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Хөтөлбөрийн код	Үзүүлэлт	Тохируулга
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	128,930,717.39
5	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	128,930,717.39
6	Улсын төвлөрсөн төсвөөс	128,930,717.39
7	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	128,930,717.39
8	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	128,930,717.39
9	УРСГАЛ ЗАРДАЛ	128,930,717.39
13	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,930,717.39
14	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	128,930,717.39
15	Төвлөрүүлэх шилжүүлэг	128,930,717.39

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,643,410.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,643,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,900,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,400,000.00
210401	Бичиг хэрэг	820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	580,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,743,410.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	2,743,410.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,643,410.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,643,410.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,143,410.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Эрдэнэхүүд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсөвт байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг дагаж мөрдөх, анхан шатны баримтын хүчин төгөлдөр байдал, цалингийн тооцоолол, холбогдох шийдвэрийг дагаж мөрдөх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дүгээр сарын 20-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Бэст фортуна аудит ХХК-ийн аудитор Н.Эрдэнэбат ахлагчтай 4 хүнтэй баг хариуцаж хэрэгжүүлэв.

Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Бэст фортуна аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/11 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь үйлчлүүлэгчийн эрхийг хүндлэн дээдэлж, сэргээн засах эмчилгээ сувилгаа үзүүлэх, тодорхой хөтөлбөрүүдэд хамруулан чадавхжуулах, хөгжүүлэх, цаашид удаан амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, амьдрах ухааны дадал чадвар эзэмшүүлэх, нийгэмшүүлэх, аюулгүй орчноор хангахад оршино.

Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Ахмад настныг тэжээн тэтгэх хүүхэдгүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх хүүхэд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас дэмжлэг тусалцаа үзүүлэх чадваргүй, тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь тухайн ахмад настны эсрэг хүчирхийлэл үйлдсэн болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настнуудад:

- Үйлчлүүлэгчийг зориулалтын байранд эрүүл аюулгүй, таатай орчинд амьдруулах,
- Үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан хоол, хувцас, эм тариа, ахуйн хэрэгслээр хангах
- Үйлчлүүлэгч бүрийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, тэдний хөгжил, хамгааллын шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэх, амьдралын хэвийн нөхцлийг бүрдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах.
- Үйлчлүүлэгч бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ асаргаа сувилгааг үзүүлэх үйлчилгээ нь хүнд сурталгүй, авилгаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй байх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд доорх өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын хууль:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар (сovid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ахмад настны үндэсний төв нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн боловсруулахдаа стандарт, өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлээгүй, шаардлага хангахгүй байна.

Ахмад настны үндэсний төв 2020 онд санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд дотоод аудит хийгдээгүй байна.

Ахмад настны үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 5,434,773.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 54,347.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 3,366,958.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 33,669.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцов.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ахмад настны үндэсний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 428,161.6 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар

буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	785.1	-	(785.1)
Авлага	59,690.4	44,123.4	(15,567.0)
Бараа материал	781,174.6	708,317.2	(72,857.4)
Үндсэн хөрөнгө	11,138,069.9	10,799,117.8	(338,952.1)
Нийт хөрөнгө	11,979,720.0	11,551,558.4	(428,161.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,979,720.0	11,551,558.4	(428,161.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,979,720.0	11,551,558.4	(428,161.6)

Мөнгөн хөрөнгө 785.1 мянган төгрөгөөр буурсан нь кассын оны эхний үлдэгдлийг тайлангийн хугацаанд зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 44,123.4 мянган төгрөг болж 15,567.0 мянган төгрөгөөр буурсан нь туслах үйл ажиллагааны орлогын авлага барагдсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд Өгөөмөр баянбулаг ХХК 2017 онд мах нийлүүлэх сонгон шалгаруулалтаар 247,275.3 мянган төгрөгийн үнийн дүнтэй АНҮТ-2017-НТШ-02 дугаартай гэрээ байгуулж гүйцэтгэлээр үхрийн махны үнийн зөрүүгээс (мах нийлүүлэх үед махны үнэ эрс өссөн гэх шалтгаанаар 1 кг-ийг 8.4 мянган төгрөгөөр гэрээ хийсэн боловч оны төгсгөлд 15.0 мянган төгрөгөөр гэрээний нэмэлт хийсэн 43,215.4 мянган төгрөгийн үлдэгдэл) үүссэн авлага байна. Дээрх авлагын талаар Өгөөмөр баян булаг ХХК өглөгийг барагдуулах боломжгүйгээ илэрхийлсэн 1/135 дугаартай албан тоотыг 2019 оны 06 дугаар сарын 26-нд ирүүлсэн байна. Төв аймгийн шүүхэд 2020 онд нэхэмжлэл гаргасан боловч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан захирамж гарсан тул эрсдэлтэй авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 708,317.3 мянган төгрөг болж 72,857.3 мянган төгрөгөөр буурсан нь хангамжийн материал үүний дотор аж ахуйн материалын үлдэгдэл 74,180.2 мянга, малын үлдэгдэл 9,3910.0 мянган төгрөгөөр буурч эмийн үлдэгдэл 11,232.7 мянган төгрөгөөр өссөн, байгууллагын даргын тушаалаар 47,258.3 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйл акталсан, 9,680.0 мянган төгрөгийн малын хорогдол гарсан, малын нас дэвшилт 15,300.0 мянган төгрөгийн орлого авсанаас шалтгаалжээ.

Оны эцэст 12 дугаар сард бэлтгэсэн 132,000.9 мянган төгрөгийн цэвэрлэгээний материал, эм тариа, нормын хувцас, зөөлөн эдлэл, малын тэжээл, маск, пампарс, нүүрс, мах, хүнсний материал худалдан авсанаас мах, хүнсний материал нийт худалдан авалтын 48.3 хувь, нүүрс 14.5 хувийг тус тус эзэлж байгаа нь хүнсний материалын хадгалалтын хугацаа, эмийн хүчинтэй хугацаа дуусах эрсдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,799,117.8 мянган төгрөг болж 338,952.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр болон өөрийн хөрөнгөөр худалдан авсан 16,219.4 мянга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас үнэ төлбөргүйгээр 7,629.8 мянган төгрөгийн үнэтэй 5 ширхэг компьютер хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн 363,901.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, 13,620,8 мянган төгрөгийн актлагдсан хөрөнгийг ТӨБЗГ-ын 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоолын дагуу дуудлага худалдаанд оруулж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 192.5 мянган төгрөгөөр буурсан нь программ хангамжийн тайлант оны хасагдуулгаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,551,558.4 мянган төгрөг болж 428,161.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант жилийн үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Ахмад настны үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 410,960.5 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс туслах үйл ажиллагааны орлого 243,345.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 450,181.5 мянган төгрөгөөр тус тус буурч үндсэн үйл ажиллагааны орлого 24,711.6 мянга, санхүүжилтийн орлого 266,855.1 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна. Энэ нь өмнөх онд газар эзэмших эрх, хандиваар хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 224,018.1 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар буурч өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, нэмэгдэл урамшууллын зардал 161,361.3 мянга, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 34,654.5 мянга, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр бараа үйлчилгээний бусад зардал нийт 28,002.3 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Цалин, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бууралт нь батлагдсан орон тооноос 16 хүнээр дутуу ажилласнаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,087,486.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 69,856.3 мянган төгрөгөөр бууруулж 3,017,630.6 мянган төгрөгөөр баталсан байна. Цалин хөлс болон урамшууллын зардлын 159,489.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын 26,593.7 мянга, хангамж бараа материалын зардлын 18,397.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн төлөвлөгөөг 15,665.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглалтын зардлын 21,935.0 мянга, нормативт зардлын төлөвлөгөөг 226,583.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 3,161,364.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,422,929.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 723,245.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,279,195.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 587,711.8 мянган төгрөг, нийт 2,866,907.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,779,207.7 мянган төгрөгийг зарцуулж 87,577.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Санхүүжилт 143,733.5 мянган төгрөгөөр дутуу олгогдсон нь орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,793,612.4 мянган төгрөг буюу 92.6 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 196,015.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил худалдан авах зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр бараа үйлчилгээний бусад зардал нийт 28,002.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого төлөвлөсөн хэмжээнээс 135,533.2 мянган төгрөгөөр дутуу бүрдсэн нь Ковид-19 цар тахлаас хамааран амралт, сувиллын орлого буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 210 мэдээллээс хугацаандаа оруулсан 163 мэдээлэл, 387,637.0 мянган төгрөгийн 47 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- a) Өмнөх оны гүйцэтгэл, санхүүгийн тайлан байршуулаагүй
- b) 1-12 сарын санхүүжилтийн орлогын 26 гүйлгээ, 2, 4, 6, 7, 8, 9 саруудын нийгмийн даатгалын шимтгэл, засварын ажлын хөлс, ХХОАТатварт шилжүүлсэн 21 удаагийн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй
- c) Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг 7, 8, 9, 10 саруудад тайлбар хийгээгүй
- d) 2 дугаар улирлын мэдээлэл байршуулаагүй,
- e) 5 саяас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг дутуу байршуулсан 9 дүгээр сарын орлого, зарлагыг задлахгүйгээр нэгтгэн шивсэн

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 448,521.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 785.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,843.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 430,852.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,040.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгөв.

3.9.1. Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Бэлэн мөнгөний кассын эхний үлдэгдэл 785.1 мянган төгрөг нь мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл, зарцуулалтаар тайлагнаагүй байсныг аудитын явцад залруулга хийлгэв.

3.9.2. Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 440,695.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9,843.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 430,852.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Ажиллагсдын нэмэгдэл, үр дүнгийн мөнгөн урамшууллыг алдаатай тооцоолон илүү олгосон 1,647.1 мянга, Хувь хүний албан татварыг суутгаагүй 8,196.5 мянга, нийт 9,843.5 мянган төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-д “үнэн зөв байх”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3. “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл, урамшуулал, суутгаагүй татвар нийт 9,843.5 мянган төгрөгийн Төлбөрийн акт тогтоов.

2. Шилэн дансны цахим хуудсанд 387,637.0 мянган төгрөгийн 47 мэдээлэл байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалтуудтай нийцэхгүй, үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3. Өгөөмөр баянбулаг ХХК 2017 онд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтаар 247,275,279 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж гүйцэтгэлээр мах нийлүүлэх үед махны үнэ эрс өссөн гэх шалтгаанаар тендерийн бичиг баримтын хавсралтад заасан үнэ, тухайн үеийн зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлж, төлбөрийн зөрүү 43,215.4 төгрөгийн үлдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй, тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, оршин байх, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

3.9.3. Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 7,040.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

1. Малын нас дэвшилт, төлийн хорогдол, төл бойжуулалт, малчдад өгсөн малаас авах бүтээгдэхүүний даалгавар, малчидтай хийсэн гэрээ, гэрээний гүйцэтгэл нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас алслагдмал байрлалтай тус байгууллагад талбар дээрх аудитын биет тест хэрэгжүүлэх боломж гараагүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Бэлэн мөнгөний кассын тайланд сувилалын 7,040.0 мянган төгрөгийн орлогыг бүртгээгүй, банкин дахь харилцах дансанд шууд тушаасан нь Төсвийн байгууллагын мөнгөн ажиллагааны журмын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.9. “Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого, зарлагын баримтыг бичиж байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх” 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэсэн заалтуудтай нийцэхгүй үнэн зөв байх, эрх үүрэг батламж мэдээдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Бэлнээр орсон орлогыг нуун дарагдуулах, ашиглах, дутуу тайлагнах, мөнгөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх

1.3. Өгсөн зөвлөмж:

Амрагч, сувилуулагчид алслагдмал, харилцаа холбоо барьж чадаагүй зэрэг шалтгаануудаас хамаарч орлого бэлнээр тушаасан тохиолдолд бэлэн мөнгө хүлээн авсан кассын баримт бичиж, гарын үсгээр баталгаажуулан банкинд тушааж байх ба кассын тайлан гаргаж, нягтлан бодох бүртгэлд кассын гүйлгээг бүртгэж байх, холбогдох хууль, журмын заалтуудыг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг дахин давахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

1. Ахмад настнуудад эмийн зардал тодотгосон төсвөөр 68,095.3 мянган төгрөгөөр батлагдсан байхад 137,010.8 мянган төгрөгийн эм, тарианы худалдан авалт хийж, 125,778.1 мянган төгрөгийн зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд дүнгээр тайлагнасан байна. Тайлангийн жилийн эцэст 169 нэрийн 20,843 ширхэг, 41,692.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эхний үлдэгдэлээс 11,232.8 мянган төгрөгөөр нэмэгдэж үлдэгдэл их хэмжээтэй байгаа, эмийн зарлагын баримтыг сараар нэгтгэн үйлдсэн,

2. Нэр бүхий (сыр, шар будаа, мөөг, аарц, печень, пүнтүүз, жимс) зэрэг зарим хүнсний материалын нөөцийг 6-12 сараар бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Эм, хүнсний материалын олон сарын нөөц бэлтгэснээс хадгалалт, ашиглалтын хугацаа дуусч, төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэл үүсч болзошгүй

2.3. Өгсөн зөвлөмж:

Эм, хүнсний материалыг их хэмжээгээр нөөцлөхгүй, хугацаа дуусах дөхсөн эм тариа худалдан авахгүй байх, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай тушаалаар баталсан СТ-27 маягыг хөтөлж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн нь хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэсэн заалтуудтай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Өмч хөрөнгийн худалдан авалт, зарцуулалт, ашиглатанд тавих хяналт суларснаас өмч хөрөнгө үрэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн байгууллагын хөрөнгө, санхүүгийн байдалд шалгалт хийх жилийн төлөвлөгөө гарган, шалгалтыг үр дүнтэй хийж, зөрчилтэй асуудалд акт тавих, албан шаардлага, зөвлөмж өгч хэвших

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг дахин давтахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд шинэчлэн боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй, хамааралтай нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтүүд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, стандартын өөрчлөлтийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” заалттай нийцэхгүй үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал алдаатай хөтлөгдөж, тайлагнагдах

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан, стандартын дагуу сайжруулах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Алдаа, зөрчлийг дахин давтахгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудита ар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			САГ-2021-363-СТА-ТШЗ -
Шалгагдсан байгууллагын нэр:	Ахмад настны үндэсний төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажиллагсдын нэмэгдэл, урамшууллыг алдаатай тооцоолж илүү олгосон, ХХОАТатвар суутгаагүй	9,843.5	Акт тогтоосон	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
2	Шилэн дансны цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулаагүй. Үүнд: Өмнөх оны гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүжилтийн орлогын 1-12 сарын 26 гүйлгээ, 2, 4, 6, 7, 8, 9 саруудын НДШ, засварын ажлын хөлс, ХХОАТатварт шилжүүлсэн 21 удаагийн гүйлгээ, 2 дугаар улирлын мэдээлэл байршуулаагүй, орлого, зарлагын 5 саяас дээш мөнгөн гүйлгээг дутуу байршуулсан, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг 7, 8, 9, 10 саруудад тайлбарлаагүй, орлого, зарлагын 9 дүгээр сарын гүйлгээг задлахгүйгээр нэгтгэн шивсэн	387,637.0	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
3	Өгөөмөр баянбулаг ХХК 2017 онд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтаар 247,275,279 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж гүйцэтгэлээр мах нийлүүлэх үед махны үнэ эрс өссөн гэх шалтгаанаар тендерийн бичиг баримтын хавсралтад заасан үнэ, тухайн үеийн зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлж, төлбөрийн зөрүү 43,215.4 төгрөгийн үлдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй, тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулаагүй байна.	43,215.4	Албан шаардлага	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
4	Сувилалын орлогыг бэлнээр авч мөнгөн кассын бүртгэлээр дамжуулахгүйгээр банкин дахь харилцах дансанд шууд тушаасан	7,040.0	Зөвлөмж өгсөн	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй

5	<p>1. Ахмад настнуудад эмийн зардал тодотгосон төсвөөр 68,095.3 мянган төгрөгөөр батлагдсан байхад 137,010.8 мянган төгрөгийн эм, тарианы худалдан авалт хийж, 125,778.1 мянган төгрөгийн зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн тайланд дүнгээр тайлагнасан, жилийн эцэст 169 нэрийн 20,843 ширхэг, 41,692.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь оны эхний үлдэгдэлээс 11,232.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаартай тушаалаар баталсан СТ-27 маягт хөтлөөгүй, эмийн зарлагын баримтыг сараар нэгтгэн үйлдсэн</p> <p>2. Нэр бүхий (сыр, шар будаа, мөөг, аарц, печень, пүнтүүз, жимс) зэрэг зарим хүнсний материалын нөөцийг 6-12 сараар бэлтгэсэн</p>	0	Зөвлөмж өгсөн	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
6	Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөл, дотоод хяналт шалгалтын мэргэжилтэн нь хөрөнгө, санхүүтэй холбоотой тодорхой ажил хийгээгүй	0	Зөвлөмж өгсөн	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2019 онд шинэчлэн боловсруулсан боловч байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтүүд, нягтлан бодох бүртгэлийн бодлого бүрэн тусгагдаагүй, хамааралгүй дансны бичилт, бодлого тусгасан, стандартын өөрчлөлтийг тусгаагүй	0	Зөвлөмж өгсөн	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрдэнэхүү С.Нэргүй
ДҮН		447,735.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 418/АО170077

Улаанбаатар хот

САР - 2021/363/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Ажиллагсдын төрийн албанд ажилласан жилийн, ур чадварын, эмчийн зэрэг дэвийн нэмэгдлүүдийг үндсэн цалингаас тооцоолон 1,348,324.00 (Нэг сая гурван зуун дөчин найман мянга гурван зуун хорин дөрвөн) төгрөгийг илүү олгосон,
2. Төсвийн шууд захирагч өөртөө 298,747.00 (хоёр зуун ерэн найман мянга долоон зуун дөчин долоон) төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгох тушаал гаргасан.
3. Өндөр насны тэтгэврээ тогтоолгон ажиллаж байгаа 11 хүний цалингаас 8,196,459.00 (Найман сая нэг зуун ерэн зургаа дөрвөн зуун тавин есөн) төгрөгийн Хувь хүний орлогын албан татвар суутгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ахмад настны үндэсний төвийн цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, албан татварын нийт 9,843,530.00 (есөн сая найман зуун дөчин гурван мянга таван зуун гучин) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, Ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ТҮВШИНЗАЯ
Ж.ОЮУНЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0225auditin 2-R Газар46.Docx

001090533



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 172/АД/70077

Улаанбаатар хот

САТ-2021/303/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өгөөмөр баянбулаг ХХК 2017 онд мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх нээлттэй тендер шалгаруулалтаар 247,275,279 төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулж гүйцэтгэлээр мах нийлүүлэх үед махны үнэ эрс өссөн гэх шалтгаанаар тендерийн бичиг баримтын хавсралтад заасан үнэ, тухайн үеийн зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлж, төлбөрийн зөрүү 43,215,400 төгрөгийн үлдэгдлийг хүлээн зөвшөөрөхгүй, тооцоо нийлж үлдэгдэл баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өгөөмөр баянбулаг ХХК-иас авах махны үнийн зөрүүгийн 43,215,400 төгрөгийн авлагыг барагдуулж, биелэлтийг 2021 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүүд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР
"БЭСТФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.ТҮВШИНЗАЯА

Ж.ОЮУНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 173/АО170077
СМН-2021/363/СТЭ-ТЦЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ахмад настны үндэсний төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 210 мэдээллээс 387,637.0 мянган төгрөгийн 47 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 гүйлгээний холбогдох тушаал шийдвэрийг байршуулаагүй байна. Үүнд:

Өмнөх оны гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүжилтийн орлогын 26 гүйлгээ, Нийгмийн даатгалын шимтгэл, засварын ажлын хөлс, ХХОАТамварт шилжүүлсэн нийт 21 удаагийн гүйлгээ, Батлагдсан төсөө, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг 7,8,9,10 саруудад тайлбарлаагүй, 2 дугаар улирлын бүх төрлийн мэдээлэл, 5 саяас дээш орлого, зарлагын 2 гүйлгээг байршуулаагүй, орлого, зарлагын 9 дүгээр сарын гүйлгээг задлахгүйгээр нэгтгэн шивсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан

“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-т заасныг үндэслэн
ШААРДАХ нь:

1. Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулж хэвших, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 6 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ахмад настны үндэсний төвийн дарга Л.Эрдэнэхүү, ерөнхий нягтлан бодогч С.Нэргүй нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Г.ТҮВШИНЗАЯА

“БЭСТФОРТУНА АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

